



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Тавантолгой дулааны цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 170,400,000.00 (нэг зуун далан сая дөрвөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу ашиглах хугацаа үнийг шинэчлэн тогтоож балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дэд дарга А.Ариунболд, “Тавантолгой дулааны цахилгаан станц” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Тэнгэр, “Засгийн газрын автобааз” Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн
217 дугаар тогтоолын хавсралт

“ТАВАНТОЛГОЙ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Автомашини марк улсын дугаар	Ашиглал- тад орсон огноо	Арлын дугаар	Балансын нийт			Үлдэгдэл өртөг	Шинээр бүртгэх үнэ	Цаашид ашиглах хугацаа	Шилжүүлэн авах байгууллага
				үнэ	Хуримтлагдсан элэгдэл	(төгрөг)				
1	Тоёото Лексус-570 70-02 УБУ	2013.05.25	JT JHY7AX0A4 034320	130,000,000.00	130,000,000.00	-	-	21,000,000.00	2 жил	"Засгийн газрын автобааз" УТҮГ
2	Хьюндай Старекс 14-45 УНУ	2013.06.05	KMJWA37RAD U568747	40,400,000.00	40,400,000.00	-	-	6,000,000.00	2 жил	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НИЙТ ДҮН				170,400,000.00	170,400,000.00	0.00	0.00	27,000,000.00		
				(нэг зуун далан сая дөрвөн зуун мянган)				(хорин долоон сая)		